

## ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА, БОДЛОГО, ЧИГЛЭЛ

БСШУСЯ-ны Дээд боловсролын газрын дарга,  
доктор, профессор Т. Амаржаргалан

### Дээд боловсролын хөгжлийн хандлага

Дэлхий ертөнц хурдан өөрчлөгдөж, нийгэм суурь өөрчлөлтүүдтэй тулгарч байна. Өнөөдөр энэ өөрчлөлтийг соргогоор мэдэрч, мэдлэгийн нийгмийн эрэлт хэрэгцээг хангах чадварлаг, төлөвшсөн мэргэжилтэнг бэлтгэх нь их, дээд сургуулиудын үүрэг юм.

Бид ийм бүтээлч хүнийг бэлтгэн гаргаж байна уу.

“...Монгол Улс дээд боловсролын суурийг сайн тавьсан, дээд боловсролын түүхэн хөгжилтэй орон. Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны сайн уламжлалтай, институцууд нь ч сайн тогтсон...”<sup>1</sup> хэмээн дээд боловсролын шинэчлэлийн зөвлөх .... илтгэлдээ дурьджээ. Хэдийгээр энэ салбарт зуугаад их дээд сургууль, түүний дотор магадлан итгэмжлэгдсэн 67 их, дээд сургуулиуд үйл ажиллагаа явуулж байгаа боловч төгсөгчдийн дөнгөж 40% нь сурсан мэргэжилтэйгээ холбоотой ажил хөдөлмөр эрхэлж байна. Удаа дараагийн судалгааны дүнд төгсөгчдийн ажил эрхэлж чадахгүй байгаагийн нэг шалтгааныг “Мэргэжлийн төвшин, ур чадвар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахгүй байна” гэсэн дүгнэлт гарчээ.

Энэ нь манай дээд боловсролын сургалтын мөн чанар, арга зүй, менежмент цаг үеийн өөрчлөлтийг мэдэрч, хурдтай шинэчлэгдэхгүй байгаатай холбоотой. Энэ асуудал зөвхөн Монголын төдийгүй дэлхийн олон улс орны асуудал болоод байна.

“...Дэлхий ертөнцийн өөрчлөлтийг даган боловсрол бас өөрчлөгдөх ёстой. Нийгмийн бүх салбарт гүн гүнзгий өөрчлөлт гарч байгаа учраас нийгэм, эдийн засагт өнөөдөр, тэр тусмаа маргааш хэрэгтэй байгаа ур чадвар, чадамжийг хөхиүлэн дэмждэг боловсролын шинэ хэлбэр шаардагдаж байна”<sup>2</sup> хэмээн “Боловсролын талаар дахин эргэцүүлэн бодох нь” хэмээх 2015 онд ЮНЕСКО-гоос хэвлэн гаргасан номонд бичжээ.

Мөн түүнчлэн “...Үнэн хэрэгтээ, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хурдац нь шинээр гарч ирэх мэргэжил, түүнтэй холбоотой ур чадваруудыг урьдчилан таамаглах ажлыг хүндрэлтэй болгож байна. Энэ нь илүү уян хатан боловсролын систем бий болгох, хурдацтай өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад мэргэжлийн мэдлэгийг хэрэглэх тал бүрийн ерөнхий дадал чадварыг хөгжүүлэхэд түлхэц болох, ажилтан хүн гадны нөхцөл байдалд илүү уян хатан зохицох, өөрийгөө үр дүнтэй хөгжүүлэх чадвартай, тодорхой мэргэжлийн ажилд шаардлагатай мэргэшлийн ур чадварыг амьдрал дээр хэрэгжүүлэх чадвартай байхыг шаардана...”<sup>3</sup> гэсэн байна.

Манай орны хувьд бусад улс орны боловсролын хөгжлийн туршлагыг судалж турших, өөрийн нөхцөлд тохируулан нутагшуулах замаар дээд боловсролын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх нь хөгжлийн нэн тулгамдсан шаардлага болж байна. Энэхүү

<sup>1</sup> ДБШТ-ийн олон улсын зөвлөхүүдийн хурлын зөвлөмж. Стенфордын их сургуулийн Боловсролын бодлогын төвийн захирал, АНУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх боловсролын зөвлөлийн гишүүн профессор Сюзанна Лозб, Хонг Конгийн их сургуулийн ерөнхийлөгч асан, Боловсролын сургуулийн бодлогын төвийн тэргүүн профессор Кай Мин Чен нарын зөвлөмж. 2017 он

<sup>2</sup> Боловсролын талаар дахин эргэцүүлэн бодох нь”. ШУТИС-ийн хэвлэлийн газар. 2017 он

<sup>3</sup> БСШУ-ны Сайдын 1994 оны 104, 1996 оны 50, 2005 оны 181, 2010 оны 235, БШУ-ны сайдын 2014 оны А/78, А/370, БСШУС-ын сайдын 2017 оны А/52 тоот тушаалууд

тулгамдсан асуудлуудыг шийдэхэд их сургуулиуд хоорондоо хамтран ажиллах, харилцан туршлагаа хуваалцах нээлттэй орчин, нөхцөл бүрдүүлэх нь чухал байна.


Олон улсын туршлагаас харвал өөрийн орны хөгжлийн онцлогт тохирсон боловсролын болон инновацийн тогтолцоог төлөвшүүлэн, ур чадвартай хүний нөөцийг бэлтгэж, өндөр технологийн судалгааг хөгжүүлэн, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлснээр нийгэм эдийн засгийн хөгжилд нь богино хугацаанд ахиц дэвшил гарч байна.

Монгол Улсын дээд боловсролын салбарын хөгжлийн бодлого нь “Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого”-той уялдаж, мэдлэгт суурилсан нийгмийг байгуулах, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хүмүүсийн амьдралыг дээшлүүлэх, нийгмийн тэгш байдлыг баталгаажуулахад туслаж чадах дээд боловсролын үр дүнтэй тогтолцоог бий болгохыг зорьж байгаа юм.

### Монголын дээд боловсролын салбарын өнөөгийн байдал

Дэлхийн бүх улс орнуудад өндөр мэдлэг, ур чадвартай мэргэжлийн дээд боловсролтой хүмүүс хөгжлийн хурдыг тодорхойлж байдаг. Монгол Улсын хувьд ч дээд боловсролын талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн орчинг сайжруулан, сургалтын байгууллагуудаа олон улсын жишигт нийцүүлэх, дэлхийн иргэн хүнийг бэлтгэхэд өөрийн хувь нэмрээ оруулахыг зорин ажиллаж байна.

Их дээд сургуулийн тоо. 2017-2018 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр Монгол Улсад сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 96 дээд боловсролын байгууллага ажиллаж байна.




### Зураг 1. Дээд боловсролын сургалтын байгууллагын бүтэц

Дээд боловсролын сургалтын байгууллагын тооны өсөлт 2002-2003 оны хичээлийн жилд хамгийн оргилд хүрч 185 болтол өссөн бол түүнээс хойш их, дээд сургууль, коллежид тавих шаардлагуудыг өндөржүүлснээр тоо нь байнга буурч, сүүлийн жилүүдэд тогтворжих хандлагатай байна<sup>4</sup>.

Салбарын хүний нөөц. Дээд боловсролын сургалтын байгууллагуудад нийт 12705 хүн ажиллаж байгаагийн 6724 буюу 52,9 хувь нь үндсэн багш эзэлж байна. Нийт ажиллагчдын 62.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Дээд боловсролын салбарын нийт хүний нөөцийн 68.0


хувийг сургалтын байгууллагын үндсэн чиг үүргийн, 32.0 хувийг бусад ажилтан, ажилчид бүрдүүлж байна. Гэвч эрдэм шинжилгээний үндсэн болон туслах ажилтнуудын эзлэх хувь маш бага байгаа нь цаашид судалгаанд суурилсан их сургуулийг бий болгох хүний нөөцийг хөгжүүлэхэд анхаарах гол асуудлуудын нэг юм.



Зураг 2. Дээд боловсролын байгууллагын хүний нөөцийн өнөөгийн байдал

Дээд боловсролын байгууллагын багш, судлаачдын эрдмийн зэрэг цол, албан тушаалын, зэрэглэл түүнд тавигдах шаардлагыг дахин авч үзэх шаардлагатай байна. Эрдэмтэн судлаачдын бүтээлийн үр өгөөжийг дээшлүүлэх, сургалт-судалгааны ажлын тэнцвэрт харьцааг бий болгох, гадаадын эрдэмтэдтэй хамтарсан судалгааны ажил хийх боломжуудыг өргөжүүлэх нь чухал байна. Их дээд сургуулийн судалгаа, инновацийн ажлыг улс орны тулгамдсан асуудлуудыг бодитоор шийдэхэд чиглүүлнэ.

Дээд боловсролын байгууллагуудад ажиллаж буй нийт ажиллагсадын 64,2 хувь нь төрийн өмчийн сургалт, судалгааны байгууллагуудад ажиллаж байна.




Зураг 3. Дээд боловсролын сургалтын байгууллагын өмчийн хэлбэрт ноогдох хүний нөөц болон үндсэн багш нарын эрдмийн зэргийн эзлэх хувь<sup>3</sup>

<sup>4</sup> Эх сурвалж: <http://www.mecss.gov.mn/data/1601/8HigherSta1415%20.pdf>

Суралцагчид. 2017-2018 оны хичээлийн жилийн эхэнд их, дээд сургууль, коллежид суралцагчид 155248 байгаагаас 45480 нь шинээр элссэн. Тэдний 72,4 хувь нь тухайн жилд ЕБС төгсөгч, 4,9 хувь нь бусад хэлбэрийн сургуулиас, 19,2 хувь нь ажиллагчдаас, 3,6 хувь нь ажилгүйчүүдээс элссэн байна. Өнгөрсөн хичээлийн жилд ЕБС-ийг төгсөгчдийн 85,4 хувь нь их, дээд сургуульд элссэн байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажиллах хүчний зохистой харьцаатай нийцэхгүй байгаа тул цаашид элсэлтийн бодлогод тэнцвэртэй харьцаа бий болгох талаар анхаарах шаардлагатайг харуулж байна .


2017-2018 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 130484 нь бакалавр, 20345 нь магистрант, 4295 нь доктор оюутан, 124 нь дипломын дээдээр сурч байна. Нийт суралцагчдын 84.0 хувь нь бакалавр байгаагаас харахад бид өнөөдөр үндсэндээ бакалаврын сургалтад тулгуурласан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид үүнийг өөрчлөн ахисан түвшинд суралцагчдын тоог нэмэгдүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, шинжлэх ухааны салбар чиглэлээр төрөлжүүлэн судалгаа, инновацийн ажилд төвлөрөх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үр дүнд нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэсгэх, улс орны эдийн засгийг сэргээн босгох, улмаар мэдлэгийн эдийн засагт шилжих боломж нэмэгдэх юм.

Дээд боловсролын нийт байгууллагын 18,7 хувийг төрийн өмчийн их, дээд сургууль эзэлж байгаа ч ахисан түвшний сургалтын ачааллын 60-80 хувийг үүрч байна.



*Зураг 5. Магистрантур, докторантурт суралцагчдын эзлэх хувь дээд боловсролын сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр*

Суралцагчдын мэргэжлийн чиглэлийг тодорхойлохдоо ЮНЕСКО-гоос өөрийн гишүүн орнууддаа зөвлөмж болгон батлан гаргасан “Боловсролын олон улсын стандарт ангилал” –ыг баримталж байна. Энэ хүрээнд бакалаврын 817 мэргэжлийн чиглэлийг 181 багц хөтөлбөр, магистрын 344 мэргэжлийн чиглэлийг 71 багц хөтөлбөр, докторын 118 мэргэжлийн чиглэлийг 49 багц хөтөлбөр болгон өөрчилсөн.



Зураг 7. Мэргэжлийн салбар чиглэл /хөтөлбөр/

Цаашид Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд болох хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүний боловсруулалт, арьс шир, барилгын материал, ашигт малтмалын боловсруулалт, мэдээллийн технологи, эрчим хүч, дэд бүтцэд дэвшилтэт технологийг ашиглах болон тэдгээр аж үйлдвэрийг авч явах инженер, технологичийг бэлтгэх асуудал тулгамдаж байна. Иймд дээрх салбаруудад шаардлагатай хөтөлбөрүүдийг шинээр нээх, одоо хэрэгжиж буй хөтөлбөрийг чанаржуулах, олон улс болон дотоодод магадлан итгэмжлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, түүнд элсэгч, суралцагчдад олгох тэтгэлэг, урамшууллын санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэл баримтална.

Сургалтын хөтөлбөрүүдийг сайжруулах, олон улсын түвшинд хүргэх, туршлагаас суралцах, нутагшуулахаар төрөөс дэмжиж байгаа жишээнд Герман Монголын хамтарсан ашигт малтмалын технологийн их сургууль, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл, “Инженер технологийн дээд боловсрол” төсөл, Японы аж үйлдвэрийн эрчимтэй хөгжлийг маш хурдан бодитойгоор удирдан явуулсан Технологийн коллеж буюу КООСЭН боловсролын тогтолцоог Монголд нэвтрүүлэхээр хийгдэж байгаа ажлууд зэргийг дурдаж болох юм.

Дээд боловсролын чанарын баталгаажуулалт. Бакалаврын болон магистрын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийн анхны магадлан итгэмжлэл 2004 оноос эхэлсэн. Одоогийн байдлаар магадлан итгэмжлэгдсэн 67 сургууль, 203 хөтөлбөр байна<sup>4</sup>.


Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар (APACC, ACBSP, AWEWPR, ASIIN) нийт – 15 сургуулийн 19 сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдээд байна.

Төрөөс БМИҮЗ-ийг бие даасан мэргэжлийн байгууллага болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх үйлчилгээг ил тод түргэн шуурхай байлгах бодлого барьж байна. Сургалтын хөтөлбөрийн чанар, үр дүнг бодитоор үнэлэхийн тулд Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, олон улсад болон дотоодод

<sup>4</sup> www.accmn.mn.

хүлээн зөвшөөрөгдсөн шинжээч нарыг бэлтгэх, дээд боловсролын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлэх ажлууд хийгдэж байна.

Ойрын хугацаанд боловсролын байгууллагын чанарын үнэлгээний хяналтыг тогтмол хийж, чанарын бодит өрсөлдөөн явагдах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна.




Зураг 8. Магадлан итгэмжлэгдсэн сургууль (өмчийн хэлбэрээр)



Зураг 9. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр

Инженер технологи, бизнес-эрх зүй, боловсрол зэрэг мэргэжлийн чиглэлүүдийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэл их байгаа нь тухайн хөтөлбөрөөр суралцагчдын тоо тогтмол өсч байгаатай холбоотой. **Цаашид шинээр нээх ....**



### *Зураг 10. Магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийн тоо, сургуулиар*

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн 76.0 хувийг төрийн өмчийн сургууль, 24.0 хувийг төрийн бус өмчийн сургууль эзэлж байна. Сургалтын хөтөлбөрийг шинэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, агуулга, арга зүйг сайжруулах, онол-практикын хичээлийн зохистой харьцааг бий болгох, үр дүнг бодитоор үнэлэхийн тулд дотоод чанарын хяналт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгож, чанарын хяналтыг системтэйгээр хэрэгжүүлэх чиглэл барьж байна.

Дээд боловсролын санхүүжилт. Дээд боловсролын байгууллагын санхүүжилтийн гол эх үүсвэр боловсролын зээлийн сангаар олгож байсан үндэсний тэтгэлэг /2015, 2016/ болон оюутны хөгжлийн зээл /2017, 2018/, гадаад, дотоодод суралцагчдын сургалтын төлбөр, тогтмол зардлаас бүрдэж байна. Мөн төсөл, хөтөлбөрүүдээр дамжуулан багш нарыг чадавхжуулах, сургалт, судалгааны орчны хөрөнгө оруулалтууд, судалгааны чадавхийг бэхжүүлэх, их дээд сургууль- аж үйлдвэрлэлийн түншлэлийг дэмжих, оюутны бүтээлч санал санаачилгыг дэлгэрүүлэх санхүүжилтүүд хийж байна. Энд онцлон дурьдвал ДБШТ-ийн хүрээнд 12,2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр шинээр 18 лаборатори, 1,6 тэрбум төгрөгөөр 60 судалгааны төсөл, 351 сая төгрөгөөр 117 оюутны төслийг санхүүжүүлсэн, Японы засгийн газрын буцалтгүй тусламж 174 тэрбум төгрөгөөр АШУҮИС-ийн сургалтын эмнэлэг баригдаж байгаа зэргийг нэрлэж болох юм.

#### *Төрөөс боловсролын салбар болон дээд боловсролд зарцуулж буй зардал*

	2015 он	2016 он	2017 он	2018 он
Боловсролын салбарт /сая төгрөг/	978,5	1147,6	1112,2.	1305,8
Дээд боловсролын салбарт /тэрбум төгрөг/	88,6	158,1	95,3	123,6
Дээд боловсролын салбарт /хувь/	9,1	13,8	8,6	9,4

Сургалтын байгууллагын орлогын бүтэц. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын орлогын 70-85 хувийг сургалтын төлбөр, 30-15 хүртэл хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлж байна. Үндсэн үйл ажиллагаанаас нийт орлогын ихэнх хувийг олж, төрөөс авах тогтмол зардлын санхүүжилт 5-6 хувийг эзэлж байгаа нь төрийн санхүүжилт хязгаарагдмал болохыг харуулж байна.

Төрийн бус өмчийн их, дээд сургуулиудын орлогын 96.0 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу сургалтын төлбөр, үлдсэн багахан хувийг төрийн сан болон төслийн санхүүжилт, дотуур байр, түрээсийн орлого бүрдүүлж байна.

Цаашид их сургуулийн санхүүгийн бие даасан байдлыг дээшлүүлэх, судалгаа, инновацийн үйл ажиллагаа, их сургууль-үйлдвэрлэлийн түншлэл, гадаад, дотоод хамтын ажиллагаа, төсөл, хөтөлбөр зэрэг олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

#### **Дээд боловсролын хөгжлийн бодлого, чиглэл**

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод суралцагчдад үр бүтээлтэй хөдөлмөрлөж, тогтвортой сайхан амьдрахад нь шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг

эзэмшүүлэх, зөв хандлага төлөвшилтэй болгох, насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэхээр зорьж байна<sup>6</sup>. Ийм ч учраас манай улсын бүх шатны боловсролын салбарт өөрчлөлт шинэчлэлт маш эрчимтэй явагдаж байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт: “Төрийн өмчийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг хангаж, дээд боловсролд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлнэ”<sup>7</sup> гэж дээд боловсролын талаар баримтлах дунд хугацааны бодлогыг тодорхойлсон.

Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дээд боловсролын салбарт хэрэгжих 9 зорилт (3.2.18-3.2.26) батлагдсаныг дараах байдлаар багцалж байна. Үүнд:

1. Дээд боловсролын эрх зүйн орчныг боловсронгуй болгох
2. Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх
3. Үр дүнд суурилсан боловсролын тогтолцоог хөгжүүлэх
4. Стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэх
5. Багш, оюутны хөгжил, нийгмийн баталгааг хангах зэрэг болно.

Эдгээр зорилтын хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

1. Дээд боловсролын салбарт гарч буй шинэ эрэлт хэрэгцээ, нийгмийн бүхий л салбар дахь шинэ өөрчлөлтүүдтэй уялдуулан дээд боловсролын тухай хууль эрх зүйн баримт бичиг, дүрэм журмуудад шинэ зохицуулалтын заалтуудыг цаг алдалгүй тусгаж, эрх зүйн орчны шинэчлэлийг тогтолцооны шинэчлэлтэй уялдуулан хийнэ. Хуулийн өөрчлөлт, дагалдан гарах журмуудыг төслийг боловсруулж байна. Мөн өнгөрсөн жилүүдэд боловсруулж гаргасан хөгжлийн үзэл баримтлал, мастер төлөвлөгөө, стратегийн баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг нь үнэлнэ.
2. Их, дээд сургууль, коллежийн статус, хэв шинж, байршлыг нарийвчлан оновчтой тогтоох, бэлтгэх мэргэжлийн чиглэлүүдийн индекс, тавигдах шаардлага үзүүлэлтийг боловсронгуй болгож мөрдүүлэх, мэргэжилтэн бэлтгэх ойрын, дунд, хэтийн төлөвлөлт, таамаглалыг холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагатай хамтран тодорхойлно.
3. Эдийн засгийг хөгжүүлэхэд их, дээд сургуулийн үүрэг оролцоог нэмэгдүүлж, судалгааны чадавх, үр өгөөжийг сайжруулах, үр дүнг нь зах зээлийн эргэлтэд оруулж инноваци болгох, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, зорилтыг хэрэгжүүлэхээр “Судалгааны их сургууль” үндэсний хөтөлбөр боловсруулж байна. , Тухайн сургуулийн сургалт, судалгааны үйл ажиллагаа, бизнесийн эрэл хайгуул, үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ, багш, суралцагчдын идэвхи санаачилгын үр дүнд бий болсон орлогыг ашиглах эрх зүй орчныг бүрдүүлнэ. Мөн багш, оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны чадварыг тасралтгүй дээшлүүлэх, их сургуулийн үйл ажиллагааны менежментийг сайжруулах, инновацийн төв болгон хөгжүүлэх, улс



орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах чадамжийг дээшлүүлэх, санхүүжилтийн нэмэлт эх үүсвэртэй болох боломжийг нэмэгдүүлэх чиглэлийг барина.

4. Энэ хүрээнд шинэ ашиг, орлого олох гадаад, дотоодын түншлэлийг шинэ хэлбэрүүдийг дэмжих, Оюутны өөрийн удирдлага, гаргасан бүтээлч идэвхи санаачилга, цагийн хөдөлмөр эрхлэх боломжийг өргөжүүлэх ажлыг боловсронгуй болгох, тэдний төлөвшил, хөгжил, эрүүл мэндийг асуудалд онцгой анхаарах зэрэг зорилтуудыг ойрын үед авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
5. Дээд боловсролтой чанартай мэргэжилтэн бэлтгэхэд төр, үйлдвэрлэл, бизнесийн байгууллага, мэргэжлийн олон нийтийн төлөөлөл, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг хангаж, санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгоно. Энэ зорилтыг хэрэгжүүлэхээр “Үр дүнд суурилсан боловсрол” хөтөлбөр боловсруулж байна. Ажил олгогчийн эрэлт хэрэгцээ, тэднээс авсан судалгаанд тулгуурлан сургалтын агуулга, арга зүй орчиноо сайжруулах, үнэлгээний аргачлалыг өөрчлөн, үр дүнгээ тасралтгүй хянаж чанарын баталгаажуулалтыг хийдэг цогц үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ. Ингэснээр сургалтын үр дүнг зөвхөн оюутны мэдлэгийн үнэлгээгээр бус ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшсэн байдлаар нь үнэлдэг системд шилжинэ. Олон улсын боловсролын арга зүйн стандартыг судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлж буй их, дээд сургуулиудын туршлагыг түгээх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, багш судлаач, эрдэмтэд санал бодлоо солилцох, хөтөлбөрийн чанарын шинэчлэл хийх нөхцөлийг бүрдүүлнэ. Үр дүнд нь онолын өндөр мэдлэгтэй, практик ур чадвартай, бүтээлч, зөв төлөвшил хандлагатай мэргэжилтэн бэлтгэгдэнэ.
6. Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, БМИҮЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах, сургууль, хөтөлбөрийг дотоодын болон олон улсын магадлан итгэмжлэлд үе шаттай хамруулах чиглэлд анхааран ажиллаж байна. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, хичээлүүдийн давхардлыг арилгах, залгамж холбоог сайжруулах, онол-практикын хичээлийн зохистой харьцааг бий болгох, сургуулийн орчныг сайжруулах, үйл ажиллагааг нь бодитоор үнэлэхийн тулд дотоод чанарын хяналт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгож, чанарын хяналтыг системтэйгээр хэрэгжүүлнэ. Сургалтын чанарыг дээшлүүлж, Ази номхон далайн бүсийн дээд боловсролын эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Токиогийн 2011 оны шинэчилсэн конвенцид нэгдэх бодлого баримтална.
7. Дээд боловсролын байгууллагын хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх стратегийг баримтлана. Багшид тавигдах шалгуур шаардлагыг дээшлүүлж, өндөр ёс зүйтэй, хариуцлагатай, манлайлагч, мэргэшсэн, бүтээлч санаачилгатай хүмүүсээс тодорхой шалгуураар сонгож ажиллуулдаг тогтолцоонд шилжинэ. Шинэ багшийг бэлтгэх, хөгжүүлэх, нийт багш нарын мэргэжлийн болон сургалтын арга зүйг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлж, урт богино хугацаагаар сургалтанд хамрагдах, туршлага судлах, ажлын байран дээрээ өөрийгөө хөгжүүлэх нөхцлийг сайжруулна. Багшийн ажлыг сургалт-судалгааны ажлын үр дүнгээр нь үнэлдэг тогтолцоонд шилжинэ. Их дээд сургуулийн багшийн хөгжлийн төвийг үр дүнтэй ажиллуулна. Үр дүнд нь нийгэмд багшийн нэр хүнд, ёс зүйн үнэлэмж дээшилнэ.

8. Оюутнуудын нийгмийн баталгааг хангах, тодорхой хэмжээгээр орлого олох эрх зүйн орчин, нөхцлийг бүрдүүлж сургалтын төлбөрөө төлөхөд хүндрэл, бэрхшээлгүй байлгах, эрүүл мэндийн үйлчилгээг харъяаллын дагуу авдаг, тав тухтай орчинд сурч амьдрах орчин бүрдүүлэх бодлого баримталж байна. Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор “Боловсролын зээлийн сан” байгуулж, “Оюутны хөгжлийн зээлийн журам” батлуулан зээл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна. Суралцангаа цагийн ажил эрхэлж орлого олох, хөдөлмөрийн соёлд суралцах, мэргэжлийн чиглэлээр дадлагажих боломжийг бүрдүүлэх зорилгоор “Орлоготой оюутан” хөтөлбөрийг батлуулаад хэрэгжүүлж байна. Ингэснээр оюутан залуусын боловсрол, мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх, хариуцлагатай, зөв хандлагатай хувь хүн, иргэн болж төлөвших нөхцөл, боломж дээшилнэ.
9. Их дээд сургуулиудын үйл ажиллагаа, элсэлт, төгсөлт, шилжилт хөдөлгөөний байдал, диплом олголт, бүртгэл мэдээллийг нэгдсэн нэг системд оруулж, удирдлагын шийдвэр гаргах, салбарын мэдээлэл иргэд олон нийтэд нээлттэй ил тод байх нөхцлийг хангах зорилгоор “Дээд боловсролын удирдлагын мэдээллийн систем”-ийг хөгжүүлэх ажлыг хийж байна. Дээд боловсролын тэгш хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхээр зайны сургалтын төвүүдийг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулахаар ажиллаж байна.

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр УБ, 2016 он
2. ДБШТ-ийн олон улсын зөвлөхүүдийн хурлын зөвлөмж УБ, 2017 он
3. Боловсролын талаар дахин эргэцүүлэн бодох нь УБ, 2017 он
4. БСШУ-ны Сайдын 1994 оны 104, 1996 оны 50, 2005 оны 181, 2010 оны 235, БШУ-ны сайдын 2014 оны А/78, А/370, БСШУС-ын сайдын 2017 оны А/52 тоот тушаалууд
5. Монгол Улсын Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан УБ, 2015, 2016,
6. Дээд боловсролын шинэчлэлийн төслийн тайлан
7. <http://www.mecss.gov.mn/data/1601/8HigherSta1415%20.pdf>
8. [www.acsmon.mn](http://www.acsmon.mn).